



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН "ИХ ХАНГАЙ"
СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Орон сууцны айл өрхүүд, орон сууцны хонгилд үйлчилгээ явуулж буй
түрээслэгч иргэдээс авах үйлчилгээний үнэд өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 10.8.3, 10.8.4 дэх заалт, Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 3, 4, 5, 6, 7, 8, 9, 12, 13, 14, 16 дугаар байрнуудын Сууц өмчлөгчдийн холбооны бүх гишүүдийн 2024 оны 07-р сарын 01 өдрийн хурлын тэмдэглэл, "Их-Хангай" СӨХ-ийн удирдах зөвлөлийн 2024 оны 12-р сарын 06 өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн тогтоох нь:

1. Айл өрхүүдээс авах дундын өмчлөлийн үйлчилгээний төлбөрийг 2025 оны 1 сарын 01 өдрөөс эхлэн өрх тус бүр сард 20000 төгрөгөөр тооцож тогтоосугай
2. "Их-Хангай" СӨХ-ийн орон сууцны байрны хонгилын хэсэгт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа түрээслэгчидээс Монголын сууц өмчлөгчлийн холбооны дээд зөвлөлийн тэргүүлэгчдийн 2002 оны 06 тоот тогтоолын хавсралтанд заасны дагуу 1 метр квадрат талбайг 2500-4000 төгрөгөөр тооцож түрээслэсүгэй
3. Уг тогтоолын хэрэгжүүлэн ажиллахыг "Их-Хангай" СӨХ-ийн захирал Ѕ.Нармандах, нягтлан бодогч Г.Гандерөө нарт, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хяналтын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

Удирдах зөвлөлийн дарга

Гишүүд

(Handwritten signatures)

З.Ядамцоо

Н.Зина

Б.Батзориг

Ш.Сарантуяа

Д.Мөнхсүвд

(Handwritten signature)